



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОР Д.ЗАГДЖАВ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2024.07.16 № 05

Прокурорын байгууллагад Эрүүгийн  
хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох  
мэдээлэл, баримт бичгийг шилжүүлсэн  
талаар

Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ...” гэж заасан.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1.Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасны дагуу 2020-2024 оны эхний хагас жилийн байдлаар прокурорын байгууллагад эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар шилжүүлсэн мэдээллийн тоо, дэлгэрэнгүй мэдээлэл.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, холбогдох Байнгын хорооны хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



О.АЛТАНГЭРЭЛ

2024000005